



## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА

ЦАГДААГИЙН ХЭСГИЙН АЛБАН ХААГЧДЫН ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ, ТЕХНИК ТОНОГ  
ТӨХӨӨРӨМЖ /ЧД 6,7,8 ДУГААР ХОРОО/ НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалт  
гэрээний нэр:

Цагдаагийн хэсгийн албан хаагчдын тусгай хэрэгсэл, техник  
тоног төхөөрөмж /ЧД 6,7,8 дугаар хороо/

Тендер  
шалгаруулалт  
гэрээний дугаар:

ЧДХААА Б19/04

УЛААНБААТАР ХОТ  
2019 ОН

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019.10.03

Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь эрх бүхий тендерт оролцогчдоос ЧДХААА Б19/04 дугаар бүхий “Цагдаагийн хэсгийн албан хаагчдын тусгай хэрэгсэл, техник тооног, төхөөрөмж /ЧД 6,7,8 дугаар хороо/-ийг нийлуулэх ажил”-ыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн материалыг цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50 000 /тавин мянга/ төгрөгийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-ээр банкны меркантын системийг ашиглан төлнө. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

**Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 1 жил буюу /2018/ оны аудитаар баталгаажсан жилийн эцсийн санхүүгийн тайлан ирүүлнэ.**

**Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил 2016, 2017, 2018 онуудын дундаж нь 21 000 000 /хорин нэгэн сая/ төгрөгөөс багагүй байна.**

Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил /2016, 2017, 2018/-ийн аль нэгэнд ядаж нэг удаа 21 000 000 /хорин нэгэн сая/ төгрөгөөс багагүй үнийн дүнтэй ижил төстэй компьютер, тоног төхөөрөмж, бараа нийлуулэх ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 9 000 000 /есөн сая/ төгрөгөөс багагүй байна.

Тендерийг **2019 оны 10 дугаар сарын 11 өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, Худалдан авах ажиллагааны албаны 5 дугаар давхар, 511 тоот өрөөнд **2019 оны 10 дугаар сарын 11 өдрийн 10 цаг 15 минутад** нээнэ.**

Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, IV хороо Ж.Самбууугийн гудамж-16,  
Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын II байр, Чингэлтэй дүүргийн Засаг  
даргын Тамгын газрын байр Худалдан авах ажиллагааны алба  
511 тоот өрөө, Утас : 70110769

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |  |   |
|--|---|
| 1. Тендер ирүүлэх, тендериийн нээлт              | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.  |
| 2. Тендерийн иж бүрдэл                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br><br>(а) Унийн санал;<br>(б) Унийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(е) Харьяа татварын албаны тодорхойлолт<br>(ё) Нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт<br>(ж) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт |
| 3. Тогтмол үнэ                                   | 3.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Унийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн санаалаас татгалзана.   |
| 4. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 4.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>4.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.   |
| 5. Унийн саналын хүчинтэй байх хугацаа           | 5.1. Унийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.  |
| 6. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх            | 6.1. Тендерт оролцогч унийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.<br>6.2. Бараа нийлүүлэлтийн хуваарын заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.<br>6.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.    |
| 7. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл      | 7.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь запруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.   |

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

<b>ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХУСНЭГТ</b>	
Тухайн тендер шалгаруулалтын үр дүнд гүйцэтгэх ажлын талаарх дор дурдсан өгөгдөл нь ТОӨЗ-ны холбогдох зүйл, заалтад нэмэлт мэдээлэл оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТОӨЗ-ны зүйл заалттай зөрчилдвөл энэхүү ТШӨХ-д дурдсан мэдээллийг зөв гэж үзнэ.	
<b>ТОӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>A. Ерөнхий зүйл</b>
<b>ТОӨЗ 1.1</b>	<p>Захиалагч: <i>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар</i></p> <p>Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө</i></p> <p>Төсөвт өртөг: <i>30 000 000 /гучин сая/ төгрөг</i></p>
<b>ТОӨЗ 1.1 а</b>	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ: Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ.
<b>ТОӨЗ 1.1 б</b>	<i>Тендерт оролцогч хуулийн 14 дугаар зүйлийн 14.1-14.7-д дурдсан нөхцөл үүссэн тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж ирүүлнэ.</i>
<b>ТОӨЗ 1.1 г</b>	<p>Тендерт оролцогч компани гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд дараах нэмэлт нотлох баримтыг тендерт ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>Харьяа Татварын хэлтсийн тодорхойлолт /Цахим/</li> <li>Харьяа Нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт /шишитгэл хураамжаа телсөн эсэх талаар/</li> <li>Харилцагч банкны тодорхойлолт /хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна./</li> <li>Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны /төрөлжсөн архив/ тодорхойлолт</li> <li>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтуудыг тус тус эх хувиар ирүүлнэ.</li> </ol> <p><i>/Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө телсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцно/ Дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байна.</i></p> <ol style="list-style-type: none"> <li>Тендерт оролцогч нь харьяа татвар, нийгмийн даатгал, харилцагч банк, шүүхийн байгуулагаас тендертэй холбоотой газруудаас лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл ирүүлнэ.</li> <li>Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг нотариатаар баталгаажуулж 2 талын этгээдийн иргэний үнэмлэхний хуулбарын хамт ирүүлнэ. <i>/Компанийн захирал өөрөө өөртөө итгэмжлэл гаргаж байгаа тохиолдолд нотариатаар баталгаажуулах шаардахгүй./</i></li> <li>Тендерийн баримт бичгийн Гэрээний ерөнхий болон Тусгай нөхцлийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.</li> <li>Тендерт оролцогчийн ирүүлсэн үнийн санал, тендерийн үр дүнг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ.</li> </ol>
<b>ТОӨЗ 2</b>	Энэхүү тендерт гадаадын этгээд оролцох эрхгүй бөгөөд тендерийн баримт бичиг <b>Монгол</b> хэл дээр байна. Тендерийг дагалдах аливаа баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг монгол хэл рүү баталгаат орчуулгаар

	хөрвүүлсэн орчуулгын хамт ирүүлнэ.															
ТОӨЗ 2.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа : Огноо: <b>2019 оны 10 дугаар сарын 11-ны өдөр</b> Цаг: <b>10 цаг 00 минут</b>															
ТОӨЗ 2.2	Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: Чингэлтэй дүүрэг, IV хороо Ж.Самбуунийн гудамж-16, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, Худалдан авах ажиллагааны алба Утас : <b>70110769</b>  Давхар болон өрөөний дугаар: <b>5 дугаар давхар 511 тоот өрөө</b>  Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: <b>2019 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн 10 цаг 15 минут</b>															
ТОӨЗ 3.1 (а)	Үнийн санал /маягтын дагуу ирүүлнэ /															
ТОӨЗ 3.1 (б)	Бараа нийлүүлэх нарийвчилсан хугацааны график ирүүлнэ.															
ТОӨЗ 3.1 (в)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: <b>Сүүлийн 1 жил буюу 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, дүгнэлтийн хамт ирүүлнэ.</b>															
ТОӨЗ 3.1 (в)	Борлуулалтын хэмжээ: <b>Сүүлийн 3 жил /2016, 2017, 2018/-ийн борлуулалтын орлогын дундаж нь 21 000 000 /хорин нэгэн сая/ төгрөгөөс багагүй байна.</b>															
ТОӨЗ 3.1 (в)	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн дүн: <b>9 000 000 /есөн сая/ төгрөгөөс багагүй байна.</b> Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн дунг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр тодорхойлно. <b>-Харилцагч банкин дахь дансны үлдэгдэл</b> <b>-Ул хөдлөх хөрөнгийн гэрчилгээ</b> <b>-Арилжааны банкны судлагдсан зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт</b> <b>-2018 оны Санхүүгийн тайлангаас</b> (Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дунг Сангийн сайдын 2015 оны 343 дугаар тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн загвар"-ын 3.2.2 /е/-д "Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө=Мөнгө Түүнтэй Адилтгах Хөрөнгө + Санхүүгийн хөрөнгө + Дансны авлага гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэнэ" гэж заасны дагуу тодорхойлно.)															
ТОӨЗ 3.1 (в)	Ижил төстэй бараа гэрээгээр нийлүүлсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: <b>Сүүлийн 3 жил /2016, 2017, 2018/-ийн аль нэгэнд ядаж нэг удаа 21 000 000 /хорин нэгэн сая/ төгрөгөөс багагүй үнийн дүнтэй ижил төстэй төхөөрөмж нийлүүлсэн ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.</b>															
	<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Гэрээний нэр</th> <th>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас /факс</th> <th>Төсөөт өртөг</th> <th>Дууссан, эсхүл дуусах хугацаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>ДҮН</td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table> <p>Дээрх онуудад энэхүү гэрээгээр хийгдэх ажилтай ижил төстэй техник</p>	№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас /факс	Төсөөт өртөг	Дууссан, эсхүл дуусах хугацаа	1						ДҮН			
№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас /факс	Төсөөт өртөг	Дууссан, эсхүл дуусах хугацаа												
1																
	ДҮН															

	<p>тоног, төхөөрөмж нийлүүлсэн жагсаалт ирүүлнэ. Нотлох баримт болох ажил гүйцэтгэсэн гэрээ, ажил хүлээлцсэн актын хуулбар, фото зураг тус тус ирүүлнэ.</p>
ТОӨЗ 3.1 (г)	<p>Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: <b>"Шаардлагатай"</b></p> <p><b>Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл эсвэл гэрээт борлуулагчийн итгэмжлэлийг МАЯГТ №: ТШМ-4-ийн дагуу Үйлдвэрлэгчийн гэрчилгээ, барааны гарал үүслийн гэрчилгээний хамт нотариатаар баталгаажуулж ирүүлнэ.</b></p> <p>Хэрэв дээрхи баримт бичгүүд нь Монгол хэлнээс бусад хэл дээр байгаа тохиолдолд Монгол хэл дээр баталгаат орчуулгаар орчуулж ирүүлнэ.</p>
ТОӨЗ 3.1 (д)	<p><b>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт ирүүлнэ.Үүнд:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>Компаний танилцуулага ирүүлнэ.</li> <li>Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэд багтаан захиалгчийн заасан газарт өөрийн зардлаар техник тоног, төхөөрөмж нийлүүлж хүлээлгэн өгөх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ.</li> <li>Нийлүүлэхээр санал болгож буй техник тоног, төхөөрөмжийн тус бүрийн техникийн дэлгэрэнгүй тодорхойлолт, фото зургийг тус тус ирүүлнэ.</li> <li>Баталгаат засварын хугацаа 12 сар байх шаардлагатай ба албан бичгээр мэдэгдэл ирүүлнэ.</li> </ol> <p>Санал болгосон техник тоног, төхөөрөмж нь тендерийн баримт бичгийн З дугаар булэгт заасан техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан байна.</p>
ТОӨЗ 3.1 (д)	<p>Тендерт оролцогч тал: Тендерийн материалыг ТОӨЗ -д заасан /дээрх/ дарааллын дагуу эмхэтгэж, хуудас бүрийг дугаарлаж гарын үсэг зурж баталгаажуулан, цахим хэлбэр Adobe (pdf) форматаар ирүүлнэ. Ирүүлэхдээ харагдах хэлбэр нь уншигдахаар тод гаргацтай байна. (Үнэлгээ хийхэд уншигдах боломжгүй бүдэг, дутуу, засвартай, тендерийн материалыг ирүүлсэн тохиоддолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.)</p> <p><b>Цахим худалдан авах ажиллагааны систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар тоон гарын үсэг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> –ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.</b></p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) –ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
ТОӨЗ 4	<p>Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад <b>тохишуулахгүй тоогтмол байна.</b></p> <p><b>Хувилбарт тендер ирүүлэхийг: "Зөвшөөрөхгүй"</b></p> <p><b>Тендерийн валют: Төгрөг байна.</b></p> <p><b>Тендер нээснээс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна.</b></p>

ТОӨЗ 4.1 (а)	<p>Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: <b>Чингэлтэй дүүрэг, IV хороо Ж.Самбууний гудамж-16, Нийслэлийн Нутгийн Захиргааны байгууллагуудын II байр, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр 511 тоот, Худалдан авах ажиллагааны алба Утас: 70110769</b></p> <p>Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаа нь тендер хүлээн авах эцсийн өдрөөс ажлын 5 хоногоос багагүй байна.</p>
--------------	--

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- Барааны тодорхойлолт:** Нийлүүлэх техник, тоног төхөөрөмж нь шинэ тоо ширхэг бүрэн байна.
- Стандарт:** Нийлүүлэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна. Нийлүүлэх техник тоног, төхөөрөмж нь стандартад нийцсэн, аюулгүй нөхцөл хангасан, чанартай байна.
- Бараа хүргэх газар:** Цагдаагийн хэсгийн албан хаагчдын кабинет захиалагч санал болгох.
- Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжи х нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгч ийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН НЭГДҮГЭЭР ХЭЛТЭСТ ШААРДЛАГАТАЙ  
ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

№	Тоног төхөөрөмжийн нэр	Техникийн тодорхойлолт	Тоо ширхэг
1	Зүйлдэлт принтер	Printer Laser Canon image CLASS MF3010 /MONO Laser Print, Scan Copy,A4, 18ppm, 600x400dpi, First print tyre-7.8 sec, Print Capacity 250-1,000 pages, Platen10, 64MB, Cartridge 32s,	6ш
2	Зургийн аппарат	Digital Camera: Canon EOS 7500 Kit /18-SSIS STM kit/ DIGIC 6, 24.2 pixel, APS-C, 19 point AF, ISO 100-12800, 5 fps, 3 inch,	1ш
3	Зөөврийн компьютер	NB: Dell Inspiron IS 3576 / i3-8130U, 15.6 inch HD, 4GB DDR4 2400MHz, 1TB 5400 rpm SATA Hard drive, 4 cell battery, Essential Backpack, unel (R) HD Graphics, Wi-Fi bluetooth, NK OS Black	1ш
4	Зөөврийн компьютер	NB: Dell Inspiron IS 5000 Series- 5584,(8 <sup>th</sup> Generation Intel* Core) i5-8265U, 15.6 inch FHD (1920x1080), 4GBx1, DDR4 2666MHz, 1TB S400 rpm, 2.5-in SATA 3-Cell, Essential Backpack 15 NVIDIA®, GeForcet (R), MX130 with 2GB GDDR5, Win 10 Home	1ш
5	Өнгөт принтер	Printer Ink, Canon PIXMA G3010 (Refillable ink Tank MFP (Print, Scan & Copy),B&W 8.87 ipm, Color Sipm, A4, 4800x1200dpi, FPOT Ready Color 17 sec,B&W 11 secs) Hi-speed USB 2.0 Wi-Fi, Mopria, Access Point Mode, PGI-790	6ш
6	Суурин компьютер	PC: Dell OptiPlex 3060 MT ( i3-8100, 4GB (1x4GB) 2666MHz DDR4, 1TB 7200rpm 3.5 inch, DVD /-RW, K&M, No OS	11 ш
7	Дэлгэц	Monitor: Dell 20 inch Wide FHD LED, E2016H (19.5 inch, 1600x900 at 60 Hz, VGA, Display Port with Display cable	11 ш

**Бараа хүргэх газар:** Захиалагчийн заасан газарт

**Нийлүүлэх хамгийн эхний хугацаа:** 21 хоног

**Нийлүүлэх эцсийн хугацаа:** 21 хоног

**Дөрөв. ЖИШИГ МАЯГТ**

**ҮНİЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

**Чингэлтэй дүүргийн Засаг дарга Ж.Эрдэнэбат  
танаа**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн унийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <i>[тоо]</i> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <i>[ГТН-д заасан тоо]</i> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ   | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд  |

биелүүлээгүй  
-гээс гэрээг  
цуцлах

захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.

- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: “ <b>Цагдаагийн хэсгийн албан хаагчдын тусгай хэрэгсэл, техник тоног төхөөрөмж /ЧД 6,7,8 дугаар хороо/</b> ”
ГЕН 2.1	Ажил нь: “ <b>Цагдаагийн албан хаагчдын тусгай хэрэгсэл, техник тоног төхөөрөмж</b> Ажлын талбай нь: /ЧД 6,7,8 дугаар хороо/”
ГЕН 3.1	Төслийн менежер нь: <b>Чингэлтэй дүүргийн Засаг дарга Ж.Эрдэнэбат</b>
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр <b>Гэрээ байгуулах өдрөөс эхлэнэ</b> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <b>Гэрээ байгуулсанаас хойш 21 хоног</b>
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <b>3 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.</b>
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа <b>[1]</b> жил байна. Барьцаа хөрөнгө гэрээний үнийн дүнгийн <b>5 хувь</b> байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулахб Гэрээний хугацаанд бараа нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүн <b>0,05 хувиар</b> тооцож алданги ногдуулна.  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ: гүйцэтгээгүй үүргийн үнийн дүн <b>10 хувиас хэтрэхгүй</b> .

## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

БАТЛАВ.

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

[Тендер  
шалгаруулалт/гэрээний  
нэр] гэрээ.

Дугаар № [Тендер  
шалгаруулалт/гэрээний  
дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 5.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 5.2 Бусад шаардлагатай баримт бичиг<sup>1</sup>;

- 5.3 Үнийн санал;
- 5.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
- 5.7 Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]